

ДОРНОД АЙМГИЙН
ХЭРЛЭН СҮМЫН
8 ДУГААР СУРГУУЛЬ
ЖЮДО0031

№ ...

20 ... он ... сар ... өдөр

СУРГАЛТЫН МЕНЕЖЕР ГАНХАРГАЛ



ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СҮМЫН 8 ДУГААР СУРГУУЛИЙН 6 ДУГААР АНГИЙН
СУРАГЧДАAS АВАХ МОНГОЛ ХЭЛ БИЧИГ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

ХУВИЛБАР Б

Эхийг анхааралтай уншиж даалгаврыг гүйцэтгээрэй.

ЦООРХОЙ ХУВИН

Эрт урьдын цагт Энэтхэгт нэгэн ус түгээгч хоёр хувинтай дамнуургаар ус зөөдөг байжээ. Харин хоёр хувингийн нэг нь цоорхой тул усны нь тал агарчхаад хүрдэг байв. Цоорхой хувин энэ байдлаасаа ихэд ичиж, харин бүтэн хувин нь өөрөөрөө бахархдаг байв.

Иймэрхүү байдлаар бүтэн 2 жил өнгөрч эцэст нь цоорхой хувин тэсэж чадалгүй:

- Эзэнтэн минь би өөрөөсөө ихэд ичиж байна. мөн танаас уччлал гүйхиг хүсэж байна гэжээ.

- Яагаад гэж? Усчин асуухад:

- Яагаад гэвэл би авч ирэх ёстой усныахаа дөнгөж талыг нь авч ирдэг. Тэгээд та миний энэ байдлаас болж авах ёстой мөнгөө бүгдийг нь авч чаддаггүй шүү дээ гэв. Усчин энэ үгэнд цочин хариуд нь:

- Чи буцах замдаа замын хажуу талын цэцгүүдийг хараарай гэв. Цоорхой хувин буцахдаа замын хажуу руу хартал үнэхээр сайхан цэцгүүд ургасан байлаа. Гэсэн хэдий ч хүрэх газраа ирэхэд бас л тал

устай байсан тул уччнаас уччлал гүйв. Тэгэхэд усчин:

Замын хажууд зөвхөн чиний ирэх талд л цэцгүүд ургасан. Харин нөгөө хувингийн ирсэн тал цэцэг ургаагүй байгааг ажиглав уу? гэж асуугаад:

- Үүний учир нь чамайг цоорхой болохоор чиний явдаг замын хажуугаар цэцгийн үр суулгасан юм. Ус аваад буцах замд чи тэднийг усалж сайхан цэцгүүд ургасан.

- Хоёр жилийн турш би энэ цэцгүүдийг чинь түүж эзнийхээ гэрт тавьдаг байсан. Хэрвээ энэ сайхан цэцгүүд байгаагүй бол түүний гэрт би ийм аз жаргал бэлэглэж чадахгүй байсан шүү дээ хэмээн өгүүлжээ.

- Дээрх эхийн гол санааг 25-30 үгэнд багтаан бичнэ үү.
- Дараах өгүүлбэрээс цөм бүтцийг ялан тодорхойлоорой

Эрт урьдын цагт Энэтхэгт нэгэн ус түгээгч хоёр хувинтай дамнуургаар ус зөөдөг байжээ.

- Дараах өгүүлбэрээс жинхэнэ нэр үгийг ялан бичээрэй.

Замын хажууд зөвхөн чиний ирэх талд л цэцгүүд ургаж, нөгөө хувингийн ирсэн тал цэцэг ургаагүй байгааг ажиглав уу? гэж асуув.

- "Сандлаар" гэдэг үгийн холбогдох зөв бичгийн дүрмийг тайлбарлана уу? /Зоноо/
5. Эхээс заахын тийн ялагын нөхцөлтэй угсийг ялан бичээрэй.
6. Зохиолыг зохиолын агуулгатай нь зөв харгалзууларай /5 оноо/
A. Шударга шүүгч
B. Цаасан онгоц
B. Шидэг бийр
Г. Лакшмын соёрхол
- Хүний хүсэл, үл ханах шунаг сэргэлийн талаар
2. Байгаль орчин, модоо хайрлах
3. Хүний мөн чанарыг таних
4. Аливаа хэрэг явдлыг шударгаар шүүх тухай

- Галигийг үндэсний бичгээр бичээрэй.

Минү эмэгээ эхэ мал-и эм дом, эм дом хэмэн домнун эдэгэгдэг. Хаби-йин түмэн, ах-а дэгүү бүгүдэ хамтуу тахилг-а-дуу йабудаг.



ДОРНОД АЙМГИИН ХЭРЛЭН СУМЫН 8 ДУГААР СУРГУУЛИЙН 6 ДУГААР АНГИЙН
СУРАГЧДААС АВАХ МОНГОЛ ХЭЛ БИЧИГ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

ХУВИЛБАР А

Эхийг анхааралтай уншиж даалгаврыг гүйцэтгээрэй.

ЕСДҮГЭЭР САРЫН НЭГЭН

Наран гарваас тоосно.

Манай сургуулийн давхар цагаан байшин, алаг цэцэгсийн давалгаа мэт хүүхэд багачууд, Бор багш бүгд л алган дээр минь багтана. Баасандорж бид хоёр баяр хөөртөө багтаж ядан зогсов. Аавын авч өгсөн цүнх шинэхэн номоор дүүрэн байв. Энэ жил дүү минь сургуульд орж байгаа болохоор би дүүтэйгээ хамт сургууль руугаа баяр баходал дүүрэн алхаж явлаа.

Бид хоёрыг сургуульдаа явж байх замд манай захирал Очирбат багш маань тааралдаад миний дүүгийн толгойт энхрийлэн илж “Энэ Баасандоржийг хараач ээ, цүнхнээсээ өндөргүй юм, яг л нэмэх тэмдэг дээ” гэв. Чухам нэмэх тэмдэг гэсний учрыг тэр үед ойлгоогүй ч дотроо бол сумын сургуули нэг сургачаар нэмэгдэж байгаа гэж бодож явсан юм.

Тэртээх хөх тэнгэрийн уудмаар галуун цуваа өнгөрлөө. Бас л сургуульдаа явж байгаа биз ээ гэсэн сонин бодол төрөв. Ганганаан гунганах дуу нь сэргүүн тунгалаг агаарыг хөглөнө. Сэтгэл дотор ариусаад яг л тэнгэрийн уужим цээлд нисэж явваа галуу шиг санагдаж билээ.

Хонх жингэнэнэ.

Холхи алсад биднийг даллан дуудна.

1. Эхийг уншаад дараах асуултад хариулж бичээрэй.
 - Ах дүү хоёрын баярласны учир юу вэ?
 - Алаг цэцэгсийн давалгаатай юуг адилтгасан бэ?
2. “Манай сургуулийн давхар цагаан байшин, алаг цэцэгсийн давалгаа мэт хүүхэд багачууд, Бор багш бүгд л алган дээр минь багтана.” гэсэн өгүүлбэрт байгаа жинхэнэ нэрсийг ялган бичнэ үү.
3. Дараах өгүүлбэрээс цөм бүтцийг ялган тодорхойлоорой.
“Ганганаан гунганах дуу нь сэргүүн тунгалаг агаарыг хөглөнө.”
4. “давхар, тэнгэр, уудам, баходал, тэмдэг “зэрэг үгсэд харьяалахын тийн ялгалын нөхцөлийг залгаж бичээрэй.
6. Дараах ардын аман зохиолын төрөл зүйлийг зөв харгалзуулна уу?

A. Оньсого	1. Жолоо дардаг
Б. Түргэн хэллэг	Жороо халтар
	2. Ажил хийвэл
В. Зүйр цэцэн үг	Ам тосдоно
	3. Мөчиргүй мод мориноос хурдан
Г. Ертөнцийн гурав	4. Газар үндсээр баян
	Далай усаар баян
	Тэнгэр одоор баян
7. Галигийг үндэсний бичгээр бичээрэй.

Монгол-ун хангай, гоби мингт-а, мингтан мал, анг аба-бар элбэг. Хүмүн бүхүн эхэ орун-у-бан онгтун хили-бэн улам бүри бэхилэй-э. Ангги-бан гойуба.